

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮН

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, мөн хуулийн 38 дугаар зүйлд хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулахаар заасан. Тус зохицуулалтын хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулж, улс орон даяар бүх нийтийг хамарсан өргөн хүрээний хэлэлцүүлгийг 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлүүлж, татвар төлөгч, эрдэмтэн судлаач, худалдааны танхим зэрэг бүх талын оролцоог хангуулан нээлттэй санал авах ажлаар эхлүүлж, фокус группийн судалгааг хийсэн.

Хэлэлцүүлгийн хүрээнд Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар, Эдийн засгийн хөгжлийн зөвлөлтэй хамтран улс орон даяар, давхардсан тоогоор 13,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 176 мянга гаруй саналыг хүлээн авсан.

Татварын шинэчлэлийн хүрээнд зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлгүүд нь улс орон даяар өргөн хүрээг хамарч, салбар бүрийн онцлогт тулгуурлан, олон талын оролцоог ханган зохион байгуулагдсан. Мэргэжлийн холбоод, салбарын татвар төлөгчид, хуульч, сэтгүүлч, томоохон аж ахуйн нэгжүүдийг хамруулсан хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан бөгөөд орон нутгийн түвшинд 21 аймгийн татварын газраар дамжуулан иргэд, аж ахуйн нэгжүүдийг өргөнөөр хамруулсан. Тухайлбал:

№	Зохион байгуулагч	Оролцогчид/Сэдэв	Хэлэлцүүлгийн тоо	Оролцогчийн тоо
1	Татварын ерөнхий газар	<ul style="list-style-type: none"> • Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт; • Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг; • Монголын үнэлгээчдийн холбоо; • Бусад мэргэжлийн холбоо, гишүүд, нягтлан бодогчид, сонирхогч бусад этгээд. 	1	150
2		<ul style="list-style-type: none"> • Хүнс, хөдөө аж ахуйн салбарын татвар төлөгчид; • Сонирхогч бусад этгээд. 	1	140
3		<ul style="list-style-type: none"> • Барилга болон уул уурхайн салбарын татвар төлөгчид; • Сонирхогч бусад этгээд. 	1	140
4		<ul style="list-style-type: none"> • Аялал жуулчлал болон тээврийн салбар үйл ажиллагаа явуулж буй татвар төлөгчид; • Сонирхогч бусад этгээд. 	1	130
5		Татварын албанд ажиллаж байсан албан хаагчид	1	14
6		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес инкубатор төв ТББ, иргэдийн төлөөлөл	1	11
7	Монгол Улсын Их Хурал	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	2	
8	Монгол Улсын Их Хурал	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль	1	

9		Хувь хүний орлогын албан татварын тухай хууль	1	
10	МҮХАҮТ	Хувийн хэвшил, хуульч, сэтгүүлч	1	200
11		Хувийн хэвшил, Том татвар төлөгчид	1	80
12		Хувийн хэвшил, салбарын төлөөлөл	1	80
13	Нийслэл, дүүргийн татварын газар	Татвар төлөгч иргэд	77	4,660
14	21 Аймгийн татварын газар	Татвар төлөгч иргэд	101	7,552

Улмаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу татварын хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлал, дагалдах тооцоо, судалгааны хамт 60 хоногийн хугацаанд Сангийн яамны цахим хуудас болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд олон нийтэд нээлттэй байршуулан санал авч дуусаад байна.

Энэ хүрээнд олон нийтээс Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбоотойгоор 86,025 саналыг хүлээн авч, саналуудад дүн шинжилгээ хийж, судалсан. Тус саналуудыг агуулгаар нь судлан үзэхэд нийт саналуудын 72 хувь нь татварын хувь хэмжээ, босго, 10 хувь нь хөнгөлөлт, чөлөөлөлт, 4 хувь нь хасагдах зардал, 2 хувь нь татварын тайлагнал, үлдсэн 11 хувь нь хууль тогтоомжийн ойлгомжгүй байдал зэрэгтэй холбоотой саналуудыг ирүүлсэн байна.

Утга	Нийт	Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)	Санал тусгагдсан байдал		
			Авсан	Аваагүй	Сэтгэгдэл
Хувь хэмжээ	72,641	48,398	22,473	21,654	4,271
Хөнгөлөлт, чөлөөлөлт	20,182	8,982	2,553	6,013	416
Хасагдах зардал	9,650	3,334	1,358	1,784	192
Босго	25,033	13,954	7,554	4,981	1,419
Тайлагнал	5,663	2,130	969	1066	95
Хууль тогтоомжийн ойлгомжгүй байдал	14,413	4,090	1,601	2,420	69
Татвар, гаалийн байгууллагын үйл ажиллагаа	19,459	3,546	1,609	1,937	-
Хариуцлага	2,929	798	607	191	-
Өр барагдуулалт	3,687	83	45	38	-
Бусад	2,759	710	293	397	20
Нийт	176,416	86,025	39,062	40,481	6,482

Хэлэлцүүлгийн үеэр татвар төлөгчдөөс ирүүлсэн саналыг нэг бүрчлэн судлан үзэж, нийт саналын 49 хувь буюу 39,062 саналыг хүлээн авч хуулийн төсөлд

тусгасан бол 40,481 саналыг хүлээн авах боломжгүй гэж үзлээ. Мөн үлдсэн 6,482 санал нь сэтгэгдэл, асуулт хэлбэртэй байлаа. Ирсэн саналын дийлэнх нь татварын хувийг бууруулах, НӨАТ суутган төлөгчийн босго дүнг нэмэгдүүлэхтэй холбоотой байв.

Татвар төлөгчдийн зүгээс ирүүлсэн саналд үндэслэн бизнес эрхлэгчдийг дэмжсэн, нэмэлт дарамт үүсгэхгүй, уян хатан зохицуулалтуудыг хуулийн төсөлд тусгасан.

Татвар төлөгчдөөс ирүүлсэн саналуудыг тусгайлан авч үзвэл:

Ирүүлсэн санал	Тусгасан эсэх	Тайлбар
Татварын хувь хэмжээг бууруулах	Агуулгын хувьд тусгасан	Татварын шинэчлэлийн эхний үе шат болгож Улсын Их Хурлаас Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан. НӨАТ-ын буцаан олголтын 2 хувийг шаталсан хэлбэрээр 10 хүртэл хувь болгох зохицуулалтыг баталсан.
Татвар төлөгч иргэний татварын буцаан олголтыг нэмэх	Тусгасан	Татварын шинэчлэлийн эхний үе шат болгож Улсын Их Хурлаас Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан. НӨАТ-ын буцаан олголтын 2 хувийг шаталсан хэлбэрээр 10 хүртэл хувь болгох зохицуулалтыг баталсан.
НӨАТ суутган төлөгч болох босго дүнг нэмэх	Тусгасан	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр НӨАТ суутган төлөгчийн босго 50 сая төгрөгийг 400 сая төгрөг болгож, жилийн борлуулалтын орлого нь 400 сая төгрөгөөс бага бол НӨАТ суутган төлөх үүрэг хүлээхгүй байх зохицуулалтыг тусгасан.
Албан татвар ногдуулах хугацааг орлого хүлээн зөвшөөрөх хугацаатай уялдуулах	Агуулгын хувьд тусгасан	Бизнес эрхлэгчдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн ачааллыг харгалзан татвар төлөгчид НӨАТ төлөх хугацааг 2 хүртэл сараар хойшлуулах боломж олгосон зохицуулалтыг тусгасан.
Төр өөрийнхөө ажил үйлчилгээний НӨАТ-ыг 100 хувь буцааж авах зохицуулалт нэмэх	Тусгаагүй	Төсөвт өртөгт НӨАТ-ыг шингэсэн үнээр санхүүжилтээ авдаг, худалдан авалтад төлсөн НӨАТ-аас хасалт хийнэ. Хэрэв чөлөөлбөл худалдан авалтын хасалт хийх боломжгүй, хөрөнгийн өртөг өсөж, ашиг буурна. Баримтжуулах ажиллагааг ТЕХ болон бусад хуулиар зохицуулах боломжтой.

<p>Татварын илүү төлөлтийн зохицуулалтыг хялбаршуулах:</p> <p>Татварын илүү төлөлтийг суутган төлөгчийн хүсэлтээр хууль тогтоомжийн дагуу төсөвт төлөх бусад төрлийн татварын төлбөрт шууд шилжүүлэн тооцох зохицуулалттай болгох.</p>	<p>Тусгаагүй</p>	<p>Илүү төлсөн татварыг буцаан авах, бусад төрлийн татварт суутгахад НӨАТ-ын илүү төлөлт баталгаажуулах шаардлагатай.</p>
--	------------------	---

Хуулийн төсөлд олон нийтээс ирүүлсэн болон хэлэлцүүлгийн үеэр гаргасан саналтай холбоотой хуулийн төсөлд нэмж тусгасан өөрчлөлт:

Бизнес эрхлэгчдийн жилийн үйл ажиллагааны борлуулалтын орлого нь 400 сая төгрөгөөс бага бол НӨАТ суутган төлөх үүрэг хүлээх шаардлагагүй болно.

Түүнчлэн, татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшнийг харгалзан дотоод болон импортын НӨАТ-ын төлбөрийг хоёр сар хүртэл хугацаагаар хойшлуулах боломжийг бүрдүүлж, аж ахуйн нэгжийн мөнгөн урсгал, уян хатан байдлыг дэмжихээр тусгасан.

Харин олон улсын татварын стандарт, шударга татварын зарчимд нийцэхгүй, татварын тэгш байдлыг алдагдуулах эрсдэлтэй гэж үзсэн тул иргэд, аж ахуйн нэгжээс хэлэлцүүлгийн үеэр гаргасан зарим салбарын хөнгөлөлт, чөлөөлөлтийг нэмэгдүүлэх саналуудыг хуулийн төсөлд тусгаагүй болно.

---oOo---